

ЧЭНЬ ЖИНЬМИН “ШИНЭ ХЯТАД УЛСААС ГАДААДАД ОЛГОХ ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН СТРАТЕГИЙН СУДАЛГАА” НОМЫН ТУХАЙ

*Ч.Батцэцэг**

Хятадын Санься Их сургуулийн доктор, дэд профессор Чэнь Жиньмин олон жилийн судалгааныхаа үр дүнд “Шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн судалгаа” номоо 2009 онд Хятадын Нийгмийн шинжлэх ухааны академийн хэвлэлийн газар хэвлүүлсэн байна. Тэрбээр марксизмийг хятаджуулах, дэлхийн улс төр, эдийн засгийн чиглэлээр багшлахын зэрэгцээ эрдэм шинжилгээ-судалгааны ажлыг олон жил хийж иржээ. Түүний судалгааны үндсэн сэдэв нь Хятадын гадаадад олгох зээл тусламжийн стратегийн судалгаа, намын гурав дахь үеийн удирдагчдын хамтын үзэл санааны онолын харьцуулсан судалгаа, Хятадын онцлогтой социализмын онолын тогтолцооны судалгаа аж.

“Шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн судалгаа” ном нь 6 бүлэг, 22 зүйлээс бүрджээ. Үүнд: 1. Оршил. 2. Шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн онолын удирдамж болон үзэл санааны эх үүсвэр. 3. Шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийг шийдвэрлэх үзэл баримтлалын үндэс болон мөрдөх зарчим. 4. Шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийг хэрэгжүүлэх явц болон үндсэн гол онцлог. 5. Шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн хэрэгжүүлэлт, түүний тодорхой үр дүн болон оршиж буй асуудал. 6. Цаашид шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн давуу байдлын бүтээн байгуулалтыг бий болгох зэрэг болно.

БНХАУ байгуулагдах үеэр, 1949 оны 11 дүгээр сарын 8-нд Гадаад Явдлын Яам байгуулагдсаны нээлтийн баярын хурал дээр БНХАУ-ын Ерөнхий сайд Жоу Энълай, гадаад харилцааны салбар хүрээний асуудлаар хэлсэн үгэндээ: “гадаад харилцааны судалгааг хятаджуулах” зорилт тавьж, гадаад харилцааны ажлын туршлагыг цэгцтэй тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна, улмаар “гадаад харилцааны ажлыг шинжлэх ухаанчлах, системчлэх ингэснээр нэг хаалганы судалгаа болно”¹ гэсэн саналыг дэвшүүлжээ. Үүнээс хойш жаран жилийн дараа зохиогч Чэнь Жиньмин шинэ Хятад улсын “гадаад харилцааны судалгааг хятаджуулах” асуудлыг үргэлжлүүлэх саналыг хөндөж тавьжээ. Тэрбээр цуглуулсан материал, сурвалж бичгийг боловсруулан “гадаад харилцааны судалгааг хятаджуулах” мэргэжил, салбар хүрээний судалгааны үүднээс уг номыг бичсэн бөгөөд энэ нь үндсэндээ түүний докторын диссертацид суурилсан зохиол аж. Зохиогч эл

* Ч.Батцэцэг - ОУСХ-гийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

номондоо БНХАУ байгуулагдсан жаран жилийн хугацаанд гадаадад олгосон зээл тусламжийн стратегийн бодлогыг холбон нэгтгэж, гүнзгийрүүлэн судалж, өөрөө анализ хийж, зээл тусламж олгож байсан улс орнуудыг он дараалалтай, хүснэгт графикаар гаргасан байна.

“Шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн судалгаа” номонд зохиогч ээдрээтэй олон үе шат, алхам алхмаар хийгдэх томоохон өөрчлөлтүүд, түүний онцлогыг өөрийн өнцгөөс харж, судалгааны хүрээнд хамрагдах шаардлагатай бүхнийг гаргаж ирэх үүрэг хариуцлагыг өөртэй тавьжээ. Ийнхүү шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн тухай энэ судалгааны гол цөмийг нийт дээрхи 6 бүлгийн агуулгад багтаасныг гурван хэсэгт хувааж үзэж болох юм. Үүнд: үндсэн суурь онолд анализ хийх, түүхийн явцад авсан арга хэмжээ болон цаашдын хэтийн төлөвд /стратеги/ өөрийн санал дүгнэлтийг хийх. Шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн онол болон бодит амьдралд хэрэгжиж байгаа нөхцөл байдал нь хоорондоо зөрчилдөж байгааг илрүүлэн анализ хийж судалжээ. Эцэст нь шинэ Хятад улсаас гадаадад олгож байсан зээл тусламжийн арга хэмжээний туршлагын сургамж, цаашид шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийг хэрхэн хэрэгжүүлэх талаар өөрийн саналыг дэвшүүлэн гаргасан байна. Зохиогч юуны түрүүнд шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн судалгааны онол болон түүнийг бодит байдалд хэрэгжүүлэх үзэл санаанд анализ шинжилгээ хийсэн байна. Нөгөөтэйгүүр шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн судалгааг нэмэгдүүлэх нь “Эв зохист дэлхий” үзэл баримтлалыг зайлшгүй бий болгох, “гурван туйлт ертөнц”-ийн онолыг хөгжүүлэх шаардлагыг хангах, Хятадын улсын эрх ашгийг хамгаалахад хэрэгтэй. Үүний тулд гадаадад олгох зээл тусламжийн стратегийн онол өөрөө баялаг байх ёстой гэсэн шийдэлд хүрчээ. Хоёрдугаар бүлэгтээ, шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн онолын удирдлага болон үзэл санааг гурван талаас нь гүнзгийрүүлэн авч үзжээ. Үүнд: нэгд. Марксизмын хүмүүнлэгийн зарчим /гуманизм/ болон “хүн төрөлхтнийг чөлөөлөх” үзэл баримтлал, эх орноо хайрлах үзэл болон олон улсын харилцаанд зохицуулсан хамтын онол, “гурван туйлт ертөнц” болон “дорно, өрнө, өмнөд, хойд” гэсэн онол, “шинэ аюулгүй байдлын үзэл баримтлал”, “эв зохист дэлхий” гм үзэл баримтлал, онолыг дэвшүүлж, шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийг хэрэгжүүлэх онолын чиглэл удирдлагыг заажээ. Хоёрт. Хятадын бахархал болсон уламжлалт соёл дахь хүнийг хайрлах үзэл, ихэс дээдэс болон эгэл ардын дунд олон нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж байх үзлийг хэрэгжүүлж, шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл

тусламжийн стратегийг хуримтлуулснаар соёлын агуулгын мөн чанарыг гүнзгийрүүлэн бэхжүүлэх болно гэжээ. Гуравт. Хятад улсын өмнөд өмнөдийн хамтын ажиллагааны онолыг хөгжүүлэх, өрнөдийн орчин үеийн үзэл санаа болон идеализмын онолын гадаадад олгох зээл тусламжийн онол түүнчлэн харилцан зэрэгцэн орших онолоор шинэ Хятад улсын гадаад зээл тусламжийн стратегийг хэрэгжүүлэхдээ бусдын алдааг давтахгүй байх шүүмжлэл тавьсан байна. Хятад улс нь өнгөрсөн 50 гаруй жилийн хугацаанд гадаадад зээл тусламжийн арга хэмжээг янз бүрийн чиглэлээр хэрэгжүүлж ирсэн бөгөөд тусламж авсан гадаадын улс орны тоо нийтдээ 190 гаруй болж, бусад хөгжиж буй оронд Хятад улсын тусламжтай бүтээн байгуулалтын 1600 гаруй төслийг хэрэгжүүлж, гадаадад илгээсэн инженер-технологийн ажилтны тоо нийтдээ 500 мянгаар тоологдож, түүнээс хойш илгээсэн эмнэлгийн баг эдүгээ 54000 гаруй хүнээс давж, зээл тусламжаар сурч боловсорсон хүний тоо ойролцоогоор мянгад хүрчээ.² Мөн Хятад улс 1983-2000 онд гаргасан НҮБ-ын нээлттэй дүнгээр, дэлхийн хүнсний хөтөлбөр зэрэг олон улсад зохион байгуулсан олон талт арга хэмжээнд маш их хэмжээний зээл тусламж нийлүүлсэн байна.

Өөрчлөлт шинэчлэл, гадаадад нээлттэй бодлого хэрэгжүүлж эхэлснээс хойш Хятад улс гадаадад зээлээр олгосон мөнгөний хэмжээ 20-р зууны 70-аад оны эхэн үе гэхэд харьцангуй цөөн байсан боловч бусад зээл тусламжийг маш өргөн хүрээтэй, их хэмжээгээр үргэлжлүүлэн хүргэж байв. Үүнд: Ази, Африк, Өмнөд Америк болон Өмнөд Номхон далайн бүс нутгийн 100 гаруй хөгжиж буй оронд олгосон тусламж, өмнөх 30 жилийнхтэй харьцуулбал ойролцоогоор 1 дахин нэмэгдэж байна.³

Зохиогч 2001 оны сүүлч гэхэд Хятад улс 120 гаруй оронд янз бүрийн олон хэлбэрээр зээл тусламж олгож, тусламж авсан улс орон бүтээн байгуулалтандаа 1620 гаруй иж бүрэн төслийг хэрэгжүүлж, тусламж авсан улс орны хүчин чадал нэмэгдэж, Хятад улсын эрх ашгийг хамгаалахад үр дүнтэй болж, дэлхийн энх тайван, хөгжлийг хангах тухай бичжээ.

Хорьдугаар зууны эхний хагас гэхэд Хятад улсын гадаад зээл тусламжийн стратегийн хэрэгжүүлэлт баялаг туршлага хуримтлуулж, эцэст нь эдгээр туршлага цаашид шинжлэх ухааны үндэслэлтэй улам боловсронгуй болж, гадаадад олгох зээл тусламжийн стратегийг чухалчилснаар бусдын алдааг давтахгүй ач холбогдолтой болж байна гэжээ. Мөн шинэ Хятад улсын гадаадад олгох зээл тусламжийн стратегийн онцлог, давуу талыг гаргаж ирэхийн тулд Хятад, Америк, Япон гурван улсын баримталж буй гадаадад олгох зээл тусламжийн стратегийн харилцан адилгүй онолыг судлах, дээрхи гурван орноос явуулж буй “Өрнө-Дорны харилцаа”, нөлөөлөл, “Өмнөд-Хойдын харилцаа”, нөлөөллийг судлах нь зайлшгүй чухал хэмээсэн байна.

Эл “Шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн судалгаа” номын гол үзэл санаа нь БНХАУ гадаадын улс оронд олгох зээл тусламжийн стратегийг хэрэгжүүлэхдээ Хятадын эрт дээр үеэс уламжилж ирсэн Күнзийн сургааль, түүнээс үүдэлтэй “эв зохист дэлхий” гэсэн үзэл баримтлал, онолыг чиг баримжаа болгож, улмаар БНХАУ-аас гадаадын орнуудад зээл тусламж олгохдоо соёлын бодлогоо эн зэрэгцүүлэн тавих хэрэгтэй гэдэгт оршиж байна. Нөгөөтэйгүүр БНХАУ дэлхийн улс орнуудад зээл тусламж олгохын хирээр нэр хүнд нь өсч, эдийн засгийн хувьд тодорхой ач холбогдол, үр дүнд хүрч, улмаар дэлхий болон хүн төрөлхтөнд чухал хувь нэмрээ оруулж байгааг онцолсон бүтээл болжээ.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн судалгаа” Бээжин, 2009., т.9
2. <http://liuxiangdong.moftec.gov.cn/article/200209/20020900041993-1>
3. “Шинэ Хятад улсаас гадаадад олгох зээл тусламжийн стратегийн судалгаа” Бээжин, 2009., т.182